

Шувууны томуу, томуугийн цартахлын бэлэн байдлын судалгаа

МУИС-ийн ЭЗС-ийн Хүн Амын Сургалт,
Судалгааны Төвийн багш, судлаач, оюутнууд
Төслийн зохицуулагч Т. Навч, ахлах багш, МУИС, ЭЗС

Шувууны томуу, томуу өвчинтэй тэмцэх, сэргийлэх арга хэмжээний тухай гарсан тогтоол, шийдвэр, дүрэм журмын талаар шийдвэр гаргагчид мэдээлэл, мэдлэг сайтай байгаа бөгөөд шувууны томуу, томуу өвчинтэй тэмцэх эрх зүйн үндэс бүрдэж, засаг захиргааны нэгж, удирдлагууд өөрсдийн удирдамж, захирамж, ажлын төлөвлөгөө гарган хэрэгжүүлэх арга хэмжээ авдаг болох нь харагдаж байна. Гагцхүү хөрөнгө санхүүгийн асуудал ялангуяа, уг өвчнөөс урьдчилан сэргийлэх, цартахлын үеийн бэлэн байдлыг хангаж ажиллахад зориулагдсан тусгайлсан төсөв байхгүй байгаа нь холбогдох аливаа тогтоол, тушаал, шийдвэр, журмыг хэрэгжүүлэхэд учирч буй гол бэрхшээл болж байна.

Ухуулга нөлөөллийн дараа шувууны томуугийн халдвар дамжих замуудын талаарх хүн амын ойлголтонд ерөнхийдөө нэлээд дээшилсэн байна. Гэхдээ сурсан, мэдсэнээ амьдралд хэрэгжүүлэх, дадал хэвшил болгон амьдрах, урьдчилан сэргийлэх талаар дутагдалтай хэвээр байна.

Шувууны аж ахуй эрхлэгчид өөрсдийгөө шувууны томуугийн хүний өвчлөлөөр өвчлөх, халдварлах эрсдэл өндөртэй гэж үзэж байна. Учир нь шувууны томуу өвчин нь халдварлагдсан эд юмс, тээврийн хэрэгсэл, амьтны тэжээл, шувууны тор, ажиллагсдын хувцас хунараар дамжин тархах магадлал маш өндөртэй байдаг. Мөн шувууны аж ахуйд ажиллагсдын хувьд зориулалтын хамгаалалтын хувцас хэрэгсэл хангалтгүй, томуунаас урьдчилан сэргийлэх мэдлэгийн түвшин бага, тэдний дунд шувууны томуугийн тухай мэдээ мэдээлэл түгээх, сургалт, сурталчилгаа явуулах ажил хангалттай байж чадахгүй байна.

Шувууны болон хүний томууны талаарх мэдлэг сумын төв/хөдөөд Улаанбаатар, аймгийн төвтэй харьцуулахад бараг ялгаагүй байгаа хэдий ч мэдээлэл авах, сургалтанд хамрагдах, хүний нөөц, техник хэрэгслээр хангагдах боломж бага байна.

Судалгаанд хамрагдсан эмнэлгүүдийн дийлэнх нь шинэ болон дахин сэргээж байгаа халдварт өвчний дэгдэлтийн үед ажиллах шуурхай ажлын хэсгийг олон байгууллагуудын төлөөлөлтэйгээр байгуулсан нь сайшаалтай юм. Шуурхай ажлын хэсгүүдийн гуравны хоёр орчим хувь нь үйл ажиллагааны оператив төлөвлөгөө боловсруулсан боловч үйл ажиллагаанд зориулсан төсөв ерөнхийдөө хангалтгүй байна. Дийлэнх эмнэлгүүдэд гоц халдвараар өвдсөн өвчтөнг тусгаарлах өрөө гаргаж, бэлтгэсэн нь сайшаалтай боловч зарим газруудад өрөөний байрлал нь халдвар эсэргүүцэх дэглэм хангаж чадаагүй, мөн дийлэнх нь агааржуулалтын болон битүүмжлэлийн систем суурилуулаагүй байна. Түүнчлэн үйлчилгээний хамрах хүрээ, үйлчлүүлэгчийн тоо болон шувууны томуу дэгдэх эрсдэлтэй харьцуулахад эмнэлгүүдэд байгаа хамгаалах хувцас, хэрэгслийн хангамж, хүртээмж, ариутгалын бодисын хүрэлцээ, хангамж доогуур байна.

Түлхүүр үгс: Шувууны томуу, цартахлын бэлэн байдал, мэдлэг, хандлага, оролцоо

Энэхүү судалгааг НҮБ-ын Хүүхдийн Сангийн захиалгаар 2007 оны 4-8 сард МУИС-ийн ЭЗС-ийн Хүн Амын Сургалт, Судалгааны Төвийн багш, судлаачид хүн ам зүйн ангийн оюутнуудтайгаа хамтран хийж гүйцэтгэсэн болно.

Судалгаа нь таван үндсэн чиглэл бүхий багц судалгаа бөгөөд судалгаанаас гарсан гол үр дүнг энд танилцуулахыг зорилоо.

Үндэслэл

2003 оноос Зүүн Өмнөд Ази болон Европын олон оронд томуугийн вирусээр сэдээгдсэн шувууны томуу жил ирэх бүр хамрах хүрээгээ тэлж, амьтан, хүнд халдварлах, өвчлүүлэх хэмжээ нь нэмэгдэж байгаа нь дэлхийн улс орнуудын сэтгэлийг түгшээсэн тулгамдсан асуудал болоод байна. Иймээс ДЭМБ-аас зарлан хуралдуулсан Ерөнхий чуулганаар томуугийн болзошгүй цартахалд бэлтгэх үйл ажиллагаагаа эрчимжүүлэхийг гишүүн орнууддаа уриалсан билээ. Сүүлийн 2 жилд тэр дундаа Азийн олон оронд тухайлбал, БНХАУ, Тайланд, Япон, Өмнөд Солонгос, Индонез, Пакистан, Тайван, Кампожи, Лаос зэргийг хамарсан томуугийн вирусээр үүсгэгдсэн шувууны томуугийн улмаас олон мянган шувуу устаад байгаа төдийгүй, уг вирусээр хүмүүс халдварлан өвчилж, тэдний 80 орчим хувь нь нас баржээ.

Манайд хэдийгээр энэ өвчний хүний тохиолдол бүртгэгдээгүй боловч 2005, 2006 онд манай улсыг дамжин өнгөрдөг нүүдлийн шувуудын сүргээс уг өвчнөөр өвчилж үхсэн тохиолдлууд хэд хэд илэрснээс гадна эдийн засаг, нийгэм, арилжаа худалдааны хувьд гол түнш болдог улс орнуудад болон манай улсаас гадаад шилжих хөдөлгөөнд оролцож буй орнуудад гарч байгаа нь анхаарал татаж байгаа асуудлын нэг болоод байна.

Монгол улсын Засгийн газраас шувууны томуутай тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх олон талт арга хэмжээ авч байгаагийн нэг илрэл нь ЭМЯ-ны дэргэд Томуугийн Үндэсний төвийг байгуулж, Улаанбаатар хот болон орон нутаг дахь төвүүдээрээ дамжуулан лабораторит суурилсан тандалтыг идэвхжүүлэх ажлыг 2004 оноос эхлэн амжилттай хэрэгжүүлж байна. Түүнчлэн Япон улсын Засгийн газраас НҮБ-ын Хүүхдийн Сангаар дамжуулан хэрэгжүүлж байгаа төслийн хүрээнд хүн

амын дунд шувууны томуу өвчний тархалт, дэгдэлтээс урьдчилан сэргийлэх, энэ ажлыг оновчтой, шуурхай зохион байгуулах, халдваргүйжүүлэлт хийх, ард иргэдэд мэдлэг, дадал олгох сургалт, сурталчилгааны олон ажлуудыг хийж гүйцэтгэж байна.

Судалгааны зорилго

Шувууны томуу, томуугийн цартахлын талаар хүн ам, шувууны аж ахуй эрхлэгчдийн мэдлэг, хандлага, дадал, эрүүл мэндийн байгууллагын ажилтнуудын томуугийн цартахлын үед хариу арга хэмжээ авах чадвар, үйл ажиллагааг үнэлэх болон шийдвэр гаргах түвшнийхний оролцоонд болзошгүй аюулын үед шийдвэр гаргах талаарх мэдлэгт гарсан өөрчлөлтийг тодорхойлох явдал энэхүү судалгааны үндсэн зорилго юм.

Судалгааны аргачлал

Судалгаанд тоон болон чанарын аргыг хослуулан хэрэглэсэн бөгөөд тоон судалгаанд олон шатат, зорилтот, энгийн санамсаргүй түүвэрлэлтийн аргыг, чанарын судалгаанд санамсаргүй түүврийн аргыг ашигласан. Тоон судалгааны эхний шатанд бүс нутгийн болон шувууны аж ахуй (ШАА)-н төлөөлөл болгож Дархан-Уул, Дорнод, Хөвсгөл, Ховд, Сэлэнгэ гэсэн 5 аймаг, Улаанбаатар хотыг сонгосон ба түүврийн хоёр дахь шатанд тус бүр 2-3 сум/дүүргийг сонголоо. Түүвэрлэлтийн сүүлийн шатанд сонгогдсон аймаг, сум дүүргүүдээс 110 шийдвэр гаргагч, 254 эмч, эмнэлгийн ажилтан, 480 том хүн, 320 хүүхэд, 124 шувууны аж ахуй эрхлэгч нийтдээ 1288 хүнийг сонгож судалгаанд хамруулсан болно.

Судалгааны гол үр дүнгийн хураангуй

А. Шувууны томуу, томуугийн цартахлын бэлэн байдлыг хангахад шийдвэр гаргагчдын үүрэг, оролцоо

Судалгаанд аймаг/нийслэл, сум/дүүргийн төрийн захиргааны байгууллагууд болон бусад холбогдох байгууллагуудын шийдвэр гаргах түвшний нийт 110 хүн хамрагдав. Тэдгээрийн 68.2 хувь нь эрэгтэйчүүд, 31.8 хувь нь эмэгтэйчүүд байсан ба насны дундаж нь 42.2 жил байлаа.

Шувууны томуу, томуугийн цартахлын бэлэн байдлыг хангах талаарх шийдвэр гаргагчдын мэдлэгийн түвшин дээшилсэн байна.

Шийдвэр гаргагчдын мэдлэгийн түвшинг 5 багц асуултаар тандаж, мэдлэгийн нэгдсэн индекс тооцон үнэлж үзэхэд талаас илүү хувь нь бүрэн зөв мэдлэгтэй байв. Тэдгээрийн мэдлэгийн түвшин өмнөх судалгааны үр дүнтэй харьцуулахад эрс дээшилсэн байна. Гэхдээ шувууны цартахлын бэлэн байдлыг хангаж ажиллах талаар өөрийгөө мэдлэгтэй гэж шийдвэр гаргагчдын 73.6 хувь нь хариулсан нь тооцоолсон мэдлэгийн түвшингээс даруй 17 гаруй пунктээр өндөр байна.

Шийдвэр гаргагчдын шувууны томуу өвчинтэй тэмцэх хандлагад нэлээд ахиц гарсан байна.

Ухуулга нөлөөллийн ажил эхлэхээс өмнө арван шийдвэр гаргагч тутмын нэг нь шувууны томуу, томуу өвчинтэй тэмцэх талаар дээд байгууллагаас гаргасан тушаал, шийдвэр, тогтоол журмыг хэрэгжүүлэх боломжгүй гэж байсан бол судалгаагаар ийм хариулт өгсөн шийдвэр гаргагч гарсангүй. Харин ч уг өвчинтэй тэмцэх тушаал шийдвэрийг хэрэгжүүлэх бүрэн боломжтой гэж үзэж буй шийдвэр гаргагчид 8.4 пунктээр нэмэгдэж, талаас илүү хувь нь уг асуудалд илүү нааштай хандах болсон байна. Шувууны томуу, томуу өвчинтэй

тэмцэх, сэргийлэх арга хэмжээний тухай гарсан тогтоол, шийдвэр, дүрэм журмын талаар шийдвэр гаргагчид мэдээлэл, мэдлэг сайтай байгаа бөгөөд шувууны томуу, томуу өвчинтэй эрх зүйн үндэс бүрдэж, засаг захиргааны нэгж, удирдлагууд өөрсдийн удирдамж, захирамж, ажлын төлөвлөгөө гарган хэрэгжүүлэх арга хэмжээ авдаг болох нь харагдаж байна.

Шувууны томуу өвчинтэй тэмцэх, сэргийлэх орон нутгийн ажлын хэрэгжилтэд ахиц гарчээ.

Ухуулга, нөлөөллийн ажил эхлэхээс өмнөх үетэй харьцуулахад шувууны томуугийн талаар ард иргэдэд хүргэж буй мэдээлэл, сургалт, сурталчилгааны хүртээмж, шувууны томуугийн цартахлын үед ажиллах мэргэжлийн багийн бэлэн байдал, орон нутгийн онцгой байдлын газар /хэлтэс, алба, нэгж/-ийн бэлэн байдал, шувууны томуутай тэмцэх, сэргийлэх шийдвэрийн хэрэгжилтийн байдал зэрэгт өгсөн шийдвэр гаргагчдын эерэг үнэлгээ өссөн байна. Гагцхүү хөрөнгө санхүүгийн асуудал ялангуяа, уг өвчнөөс урьдчилан сэргийлэх, цартахлын үеийн бэлэн байдлыг хангаж ажиллахад зориулагдсан тусгайлсан хөрөнгө байхгүй байгаа явдал холбогдох тогтоол, тушаал, шийдвэр, журмыг хэрэгжүүлэхэд учирч буй гол бэрхшээл болж байна. Мөн энэ чиглэлээр орон нутгийн боловсон хүчний мэдлэг, боловсролыг дээшлүүлэх хэрэгцээ, шаардлага ч байна.

Шувууны томуугийн цартахлын бэлэн байдлыг хангах талаар шийдвэр гаргагчдын үүрэг, оролцоо нэмэгдсэн байна.

Шувууны томуу, томуугийн цартахлын бэлэн байдлыг хангаж ажиллахад шийдвэр гаргагчдын өөрсдийн оролцоо, хариуцлага чухал юм. Шийдвэр гаргагчид шувууны томуу өвчинтэй тэмцэх ажилд өөрсдийн оролцоог их гэж үнэлсэн байдал (40 хувь нь маш их, 36.4 хувь нь их) ухуулга нөлөөллийн ажил эхлэх үетэй харьцуулахад 8.6 пунктээр

нэмэгджээ. Өнгөрсөн хугацаанд шувууны томуу өвчинтэй тэмцэх ажилд шийдвэр гаргагчдын оролцоо нэмэгдсэн бөгөөд энэ нь уг ажлыг зохион байгуулах үүрэг, хариуцлага төдий хэмжээгээр дээшилснийг илтгэж байна.

Б.Шувууны томуу өвчний талаарх хүн амын мэдлэг, хандлага, дадал

Судалгаанд нийтдээ 480 насанд хүрэгчид, 320 хүүхэд хамрагдсан бөгөөд тэдний 46.6 хувийг эрэгтэйчүүд, 53.4 хувийг эмэгтэйчүүд эзэлж байв. Боловсролын хувьд, хариулагчдын 25.7 хувь нь боловсролгүй/бага, 51.6 хувь нь бүрэн бус/бүрэн дунд, 20.9 хувь нь тусгай мэргэжлийн болон дээд боловсролтой хүмүүс байлаа.

Шувууны томуугийн талаар сонссон хүүхдүүдийн хувийн жин ухуулга, нөлөөллийн ажил эхлэхээс өмнөх үетэй харьцуулахад бага зэрэг нэмэгджээ. Нийт оролцогчдын 90 гаруй хувь нь шувууны томуугийн талаар телевизээс мэдээлэл олж сонссон ба мэдээлэл авдаг эх үүсвэрүүдийн дундаж тоо 2 байв. Гэхдээ мэдээлэл авдаг эх үүсвэрүүдийн тоогоор хүүхдүүд болон 48 ба түүнээс дээш насныхан, эрэгтэйчүүд, аймгийн төв, хөдөө амьдардаг, боловсролгүй/бага боловсролтой, ажилгүй хүмүүс хамгийн бага байхад харин Улаанбаатар хотынхон дунджаар 3 мэдээллийн эх үүсвэрээс мэдээлэл авдаг ажээ. Эндээс хөдөөд мэдээлэл хүртэх боломж хотоос доогуур байна гэж хэлж болох юм.

Шувууны томуугийн халдвар дамжих замууд, өвчлөх эрсдэлийн талаар зөв ойлголт, мэдлэгтэй хүн амын хувь нэмэгдсэн байна. Шувууны томуу шувуунд бусад халдвар авсан шувуунаас халдана гэж хариулсан насанд хүрэгчдийн хувь 14 пунктээр, хүүхдүүдийн хувь 20.4 пунктээр, агаараар дамжин халдана гэж хариулсан насанд хүрэгчдийн хувь 2.8 пунктээр, хүүхдүүдийн хувь 10.2 пунктээр тус тус нэмэгджээ. Хүүхдүүдийн дунд зөв

мэдлэгийн түвшин дээшилсэн байдал насанд хүрэгчдийнхээс өндөр байгаа нь сайшаалтай байна. Эндээс өнгөрсөн нэг жилийн хугацаанд бүх нийтийг хамарсан шувууны томуугийн талаар хийсэн сургалт, сурталчилгааны ажил амжилттай явагджээ гэж хэлж болохоор байна.

Үхсэн болон өвчтэй шувуутай тааралдвал зохих албаны хүмүүст мэдээлэх журмын талаарх хүн амын мэдлэг хангалттай бус ялангуяа, хүүхдүүдийн мэдлэг хангалтгүй байна.

Судалгаанд хамрагдагсдын дөнгөж 3 хүн тутмын нэг нь л мэдээлэх журмын талаар мэднэ гэжээ. Энд анхаарал татсан асуудлын нэг бол 5 хүүхэд тутмын дөнгөж нэг нь үхсэн болон өвчтэй шувуу тааралдвал мэдээлэх журам байдаг талаар мэдэж байлаа.

Судалгаанд хамрагдагсад гараа тогтмол угаадаг бөгөөд ихэнх (95.9 хувь) нь савангаар угаадаг ажээ.

Хариулагчдын дийлэнх (92.1 хувь) нь хооллохын өмнө, 82.1 хувь нь бие зассаны дараа, 76.6 хувь нь хоол бэлтгэхийн өмнө, 76.3 хувь нь гадуур явж ирсэний дараа, 56.0 хувь нь хоол бэлтгэсний дараа, 44.5 хувь нь хооллосны дараа гараа угаадаг байна. Харин 3.5 хувь нь тогтмол угаадаггүй, үлдсэн нь ажил хийсний дараа, хүүхдээ хөхүүлэхийн өмнө гараа угаадаг гэж хариулжээ.

Хот суурин газарт шувууны мах, шувууны гаралтай бүтээгдэхүүний хэрэглээ нэмэгдэж байгаагаас гадна багагүй хувь нь бүтээгдэхүүнийг дутуу болгож, эсвэл түүхийгээр идэж заншжээ.

Гэртээ өндгөөр хоол бэлтгэж иддэг 10 хариулагч тутмын нэг нь өндгийг дутуу болгож, эсвэл түүхийгээр нь иддэг бөгөөд шувууны махаар гэртээ хоол бэлтгэж иддэг 10 хүн тутмын бараг 2 нь шүүрхий болгож, шарж иддэг гэжээ.

Телевизийн сувгуудаас мэдээлэл авдаг хүмүүсийн хувь нэмэгдэж, радио сонсогчдын хувь буурчээ.

Насанд хүрэгчдийн хамгийн өргөн ашигладаг олон нийтийн мэдээллийн хэрэгслүүдийг өмнө явагдсан суурь судалгааны дүнтэй харьцуулан үзвэл телевизийн аль ч сувгийн хувьд 2007 онд 1.2-12.1 дахин нэмэгдсэн бол радиогийн хувьд FM радио сонсдог хувь 3.8-4.7 дахин нэмэгдсэн, харин монголын үндэсний радио сонсдог гэж хариулсан хувь 5.1 пунктээр буурчээ.

Шувууны томуу өвчний талаар олонхи оролцогчид телевизээр дамжуулан мэдээлэл хүргэх нь зүйтэй гэжээ.

Судалгаанд оролцогчдын 90.9 хувь нь телевизээр, 38.8 хувь нь радиогоор, 31.0 хувь нь сонин хэвлэлээр, 19.0 хувь нь санамж, товхимол, гарын авлагаар, 16.9 хувь нь зурагт хуудсаар, 13.8 хувь нь сурталчилгааны самбараар, 7.9 хувь нь интернетээр дамжуулан хүмүүст хүргэх нь зүйтэй гэж үзсэн бол бас Засгийн газар, өрх, хэсгийн ажилтнаар дамжуулан хүргэх, мөн тусгай сургалт явуулах боломжтой гэсэн хариултууд цөөн ч гэсэн байлаа.

Хүмүүс шувууны томууны талаар дуулсан, мэдсэн ч гэсэн томуунаас сэргийлэх, хамгаалах ажлыг амьдралд хэрэгжүүлэх, дадал хэвшил болгох асуудал дээр дутагдалтай хэвээр байна.

Үхсэн болон өвчтэй шувуутай таарч байсан хүмүүсийн 11.3 хувь нь уг шувууг нүцгэн гараараа барьсан бөгөөд тэдний дөнгөж 17.5 хувь нь зохих газарт нь мэдээлсэн байна.

С.Шувууны томууны талаарх шувууны аж ахуй эрхлэгчдийн мэдлэг, хандлага, дадал

Судалгаанд нийт 124 шувууны аж ахуй эрхлэгчид хамрагдав. Тэдгээрийн гуравны нэгээс илүү хувь нь 40-49, тавны нэг нь 30-39, 18.5 хувь нь 20-29, 15.3 хувь нь 50 ба түүнээс дээш, үлдсэн хэсэг нь 19 ба түүнээс доош насныхан байгаа бөгөөд нийт

судалгаанд хамрагдагчдын насны дундаж нь 38.8, насны голч 40.0 нас байлаа.

Шувуу аж ахуйд ажиллагсдын талаас илүү хувь нь шувуутай шууд харьцдаг хүмүүс байна.

Судалгаанд хамрагдсан шувууны аж ахуйнуудад нийтдээ 825 ажиллагсад ажиллаж байгаагийн бараг 60 орчим хувь нь шувуутай шууд харьцаж, тахиа шувуу хооллох, сангас цэвэрлэх, хашаа тор янзлах, өндөг цуглуулах зэрэг ажил үүргийг гүйцэтгэдэг ажээ. Харин нийт судалгаанд оролцогчдын бараг тал хувь тахиа шувуу хооллох, хашаа хороо цэвэрлэх, өндөг цуглуулах ажилд өөрөө оролцдог бол тэдний дөрөвний гурвынх нь эхнэр/нөхрүүд болон хөлсний ажилчид энэхүү ажлыг гүйцэтгэдэг байна. Мөн судалгаанд оролцогчдын хүүхдүүд (11.3 хувь), эцэг эхчүүд (11.3 хувь) энэ төрлийн ажил үүргийг гүйцэтгэх нь цөөнгүй байна.

Шувууны аж ахуй эрхлэгчдийн шувууны томуу, түүнээс өөрийгөө хамгаалах, урьдчилан сэргийлэх талаарх мэдлэгийн түвшинг “хангалттай” гэж үнэлж болох боловч халдвар авах эрсдэлд хүргэж болзошгүй зарим буруу ойлголтууд байна.

Нийт судалгаанд хамрагдсан шувууны аж ахуй эрхлэгчдийн ихэнх нь (97 хувь) шувууны томуу өвчний талаар сонссон байна. Тэдний 96 орчим хувь нь хүн шувууны томуугаар өвчилдөг гэж хариулсан бөгөөд тэдний 87.0 хувь нь хэрвээ энэ өвчнөөр хүн өвчилбөл амь насанд үнэхээр их аюултай гэж үзэж байна. Нийт хариулагчдын 97.5 хувь нь үхсэн болон өвчтэй тахиа шувуунд хүрч болохгүй, 35.0 хувь нь шувуу болон бусад амьтны ялгадас, сангасаар бохирлогдсон ямар нэгэн гадаргуу болон газраас хол байх, 27.5 хувь нь шувуу олноор цуглардаг нуур, цөөрмийн усанд сэлэхгүй байх, 26.7 хувь нь тахиа шувууны мах бэлтгэсэн орчныг сайтар угааж цэвэрлэх, 21.7 хувь нь гараа тогтмол угааж хэвших, 11.7 хувь нь шувууны томуугаар өвчилсөн хүнээс

холдож тусгаарлах, махчин шувуунд баригдаж үхсэн амьтны сэгээр оролдохгүй байх зэрэг хариулт өгсөн байдлаас өөрийгөө хамгаалах талаарх мэдлэг хангалттай гэдгийг харж болно. Гэвч нийт хариулагчдын бараг 7 орчим хувь нь ямар нэг хамгаалах арга байхгүй, 19.2 хувь нь шувууны гаралтай хүнсний бүтээгдэхүүн огт хэрэглэхгүй байх гэсэн хариултууд өгсөн нь “буруу ташаа” ойлголт юм.

Судалгаанд хамрагдагчид шувууны томуугаас сэргийлэх арга хэмжээ авах, халдваргүйтэл, ариутгалын дэглэмийг сахих тал дээр хойрго хандаж байна.

Судалгаанд хамрагдагчдын 40 орчим хувь нь тахиа шувууг нядалсны дараагаар өд, цус, дотор эрхтэнг хогийн сав руу шууд, 8.1 хувь нь хээр гадаа ил задгай хаяж байгаа бөгөөд тахиа шувуу нь үхсэн тохиолдолд судалгаанд хамрагдагчдын тавны нэг нь хогийн сав, хашаанд, аравны нэг нь хээр гадаа шууд ил задгай хаяж байна. Түүнчлэн судалгаанд хамрагдагчдын 63.7 хувь нь шувууныхаа сангасыг шууд хаядаг, 45.2 хувь нь бордоо болгон ашиглаж, хоёр орчим хувь нь бусдад худалдаж байгаа зэрэг нь орчны ариун цэврийг бохирдуулах, элдэв нян бактер үржих, өвчний халдвар тархах эрсдлийг эрс нэмэгдүүлж буй хэрэг юм.

Шувууны аж ахуй эрхлэгчдийн тавны нэг нь шинээр шувуу худалдан авахдаа ямар нэг нөхцөл чухалчилдаггүй, бусад шувуудтайгаа цуг байлгадаг нь шувууны томуу тархах эрсдэлийг бий болгож байна.

Гэхдээ зарим нь шинэ шувууг хэдэн өдөр тусад нь байлгах (19.3 хувь), шувуугаа төрөлжүүлэх (13.7 хувь), мал эмнэлэгт очиж шинжилгээ хийлгэх (4.8 хувь), зэрлэг шувуудтай байсан эсэхийг нягтлах (2.4 хувь) зэргээр тодорхой нөхцөлтэйгээр арга хэмжээ авдаг байна. Гэтэл заримынх нь хувьд худалдаа наймааны ашиг харах зорилгоор тухайн тахиа шувууны зөвхөн өндөглөх чадвар, үнэ өртгийг харгалзан авах

тохиолдол ч цөөнгүй байдаг ажээ.

Сургалт, сурталчилгаа, мэдээллийн талаар судалгаанд хамрагдсан нийт шувууны аж ахуй эрхлэгчдийн гуравны нэг орчим нь шувууны томуу өвчний талаар мэдээлэл, сургалт, сурталчилгаанд хамрагдсан боловч мэдлэг, мэдээлэл дутмагаасаа болж нийт хариулагчдын талаас илүү хувь нь шувууны томуугаас сэргийлж чаддаггүй учир илүү их мэдээлэл шаардлагатай гэж үзэж байна.

Шувууны аж ахуй эрхлэгчид өөрсдийгөө шувууны томуугийн хүний өвчлөлөөр өвчлөх, халдварлах эрсдэл өндөртэй гэж үзэж байна.

Учир нь шувууны томуу өвчин нь халдварлагдсан эд юмс, тээврийн хэрэгсэл, амьтны тэжээл, шувууны тор, ажиллагсдын хувцас хунараар дамжин тархах магадлал маш өндөртэй байдаг. Мөн шувууны аж ахуйд ажиллагсдын хувьд зориулалтын хамгаалалтын хувцас хэрэгсэл хангалтгүй, томуунаас урьдчилан сэргийлэх мэдлэгийн түвшин бага, тэдний дунд шувууны томуугийн тухай мэдээ мэдээлэл түгээх, сургалт, сурталчилгаа явуулах ажил хангалттай байж чадахгүй байна.

Д.Эмнэлгийн удирдах болон нийгмийн эрүүл мэндийн ажилтнууд, их эмч, бага эмч, сувилагч нарын шувууны томуугийн талаарх мэдлэг, хандлага, дадал

Судалгаанд нийт 223 нь эмнэлгийн удирдах болон нийгмийн эрүүл мэндийн ажилтнууд, их эмч, бага эмч, сувилагч хамрагдсаны 38.6 хувь нь Улаанбаатар хот, 49.3 хувь нь аймгийн төв, 12 хувь нь сумын төв/хөдөөгийн эмч, эмнэлгийн ажилтнууд байв.

Судалгаанд хамрагдсан эмч, эмнэлгийн ажилтнуудын шувуу болон хүний томууны талаарх мэдлэг харьцангуй сайн байна. Судалгаанд хамрагдагчдын талаас илүү (58-78 хувь) нь шувууны томуу амьтнаас хүнд

халдварлах нь өндөр, гуравны хоёроос илүү (66-88 хувь) нь хүний томуу хүнээс хүнд халдварлах нь өндөр байдаг гэж зөв хариулжээ. Түүнчлэн судалгаанд хамрагдагчдын ихэнх нь шувууны болон хүний томууг агаар дуслын замаар халдварладаг гэж зөв хариулсан ба шувууны болон хүний томуу халдварлах бусад аргуудыг мөн тодорхой хэмжээгээр зөв хариулсан байна.

Судалгаанд хамрагдагчдын шувууны томуутай холбоотой тогтоол, шийдвэрүүдийн талаарх мэдлэг хангалтгүй байна.

Нийт судалгаанд хамрагдагчдын 44 хувь нь шинэ болон дахин сэргэж буй халдварын талаар Засгийн газар, ЭМЯ, бусад байгууллагаас гарсан тогтоол, тушаал заавруудыг мэдэхгүй байна. Тушаал, шийдвэрүүдийн талаар мэдэж байгаа хариулагчдын ихэнх нь (63 хувь) зөвхөн ЭМЯ-ны сайдын тушаалуудыг л мэддэг байна.

Шувууны болон хүний томуу эмнэлэгт дэгдэхээс урьдчилан сэргийлэх талаар судалгаанд хамрагдагчид зохих мэдлэгтэй байна.

Шувууны томуу эмнэлэгт дэгдэхээс урьдчилан сэргийлэхийн тулд тасагт хөл хорио тогтооно (63-88 хувь), халдвар авсан өвчтнийг эмнэлгээс тусгаарлана (50-80 хувь), тасгийн ариун цэврийг чангатгана (43-70 хувь) өвчтнүүдэд амны хаалт зүүлгэнэ (38-69 хувь) гэсэн хариулт аймаг, эрхэлж буй ажлаар ялгаагүй хамгийн өндөр хувьтай байна. Мөн хүний томуу эмнэлэгт дэгдэхээс сэргийлэхийн тулд өвчтнүүдэд амны хаалт зүүлгэнэ (63-92 хувь), тасгийн ариун цэврийн дэглэмийг чангатгана (44-75 хувь), өвчтнүүдэд урьдчилан сэргийлэх талаар сургалт, сурталчилгааны ажил зохион байгуулна (33-63 хувь) гэсэн хувь хамгийн өндөр байна.

Бага эмч/сувилагч нар шувууны томуугийн сэжигтэй тохиолдол илэрсэн үед мэдэгдвэл зохих албан тушаалтныг сайн мэдэхгүй байна.

Оператив төлөвлөгөөнд заасан албан тушаалтанд мэдэгдэнэ гэсэн хувь эмнэлгийн удирдах болон нийгмийн эрүүл мэндийн ажилтан/их эмч нарын хувьд өндөр байхад бусад тохиолдолд бага эмч/сувилагч нарын хариултын хувь өндөр байна. Түүнчлэн шувууны томуугийн сэжигтэй тохиолдол илэрсэн тухай хариулагчдын дийлэнх нь утас, факсаар мэдэгдэнэ гэсэн боловч мэдэгдэх хүнийхээ утсыг бараг тал орчим хувь мэдэхгүй байв.

Шувууны томуугийн дэгдэлтийн үед судалгаанд хамрагдсан эмч, эмнэлгийн ажилтнуудын ихэнх нь тодруулбал, эмнэлгийн удирдах болон нийгмийн эрүүл мэндийн ажилтан/их эмч нарын дийлэнх (72-100 хувь), бага эмч/сувилагч нарын талаас илүү (50-69 хувь) нь оператив төлөвлөгөөний дагуу ажиллана гэжээ.

ХӨСҮТ, БГХӨТГ-аас шуурхай баг дуудаад хүлээнэ, ЭМЯ-д мэдэгдэж шийд ирэхийг хүлээнэ гэсэн хариулт бага эмч/сувилагч нарын хувьд эмнэлгийн удирдах болон нийгмийн эрүүл мэндийн ажилтан/их эмчтэй харьцуулахад өндөр байна. Өөрөөр хэлбэл, эмнэлгийн удирдах болон нийгмийн эрүүл мэндийн ажилтан/их эмч нар шувууны томуугийн үед авах арга хэмжээг илүү сайн мэддэг бол бага эмч/сувилагч нарын хувьд нэг шат дамжлаг илүү буюу дээд байгууллага, албан тушаалтанд мэдэгдээд хариу хүлээдэг байна.

Судалгаанд хамрагдагчдын дийлэнх нь шувууны томуу, хүний томуугийн дэгдэлтийн үед авах арга хэмжээний талаарх сургалтанд хамрагджээ.

Судалгаанд хамрагдагчдын дийлэнх буюу 74 хувь нь тэдний ажиллаж буй эмнэлэг шувууны томуугийн дэгдэлт, хүний

томуугийн цартахал гарсан тохиолдолд авах арга хэмжээний талаар сургалт зохион байгуулсан гэжээ. Судалгаанд хамрагдагчдын талаас илүү хувь нь хамгийн сүүлд сүүлийн 6 сарын дотор шувууны томуугийн дэгдэлт, хүний томуугийн цартахал гарсан тохиолдолд авах арга хэмжээний талаар сургалтанд хамрагдсан байна.

Шувууны томуугийн цартахалтай тэмцэх, урьдчилан сэргийлэхэд багагүй хүндрэл учирдаг нь судалгаагаар харагдлаа.

Сумын төв/хөдөөгийн хариулагчдын дийлэнх (85.2 хувь) нь шувууны томуугийн цартахалтай тэмцэх ажлыг зохион байгуулахад бэрхшээл тулгардаг гэж хариулсан нь Улаанбаатар болон аймгийн төвтэй харьцуулахад даруй 1-1.3 дахин өндөр байна. Сумын төв/хөдөөд эмч нарт зориулсан сургалт, судалгааны ажил дутмаг (44.4 хувь), хөрөнгө санхүү (18.5 хувь), лаборатори, тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл муу (14.8 хувь), шувууны цартахлын талаар хүмүүсийн мэдлэг муу, сурталчилгааны ажил хангалтгүй (11.1 хувь), хүний нөөц дутагдалтай (7.4 хувь) байна.

Е.Эрүүл мэндийн байгууллагын бэлэн байдал Улаанбаатар, Дархан-Уул, Дорнод, Сэлэнгэ, Ховд, Хөвсгөл аймгийн эрүүл мэндийн нийт 30 байгууллага судалгаанд хамрагдсанаас Улаанбаатар хотын нэгдсэн дөрвөн эмнэлэг, аймгийн нэгдсэн 9 эмнэлэг, сум/дүүргийн 11 эмнэлэг, өрхийн 6 эмнэлэг байв. Эдгээрийн 15 нь зөвхөн эмнэлгийн тусламж үйлчилгээ, 14 нь нийгмийн эрүүл мэнд болон тусламж үйлчилгээг хамтад нь, үлдсэн 1 нь зөвхөн нийгмийн эрүүл мэндийн үйлчилгээг тус тус үзүүлж байна.

Эмнэлгийн бэлэн байдлыг хангахын тулд эмнэлгүүдийн дийлэнх (80 хувь) нь томуугийн дэгдэлтийн үед ажиллах шуурхай ажлын хэсэг байгуулж, үйл ажиллагаа явуулж байна. Шуурхай ажлын хэсгийн даргаар эмнэлгийн дарга, эсвэл орлогч дарга, харин нарийн

бичгийн даргаар халдварын их эмч, их эмч нар зонхилон ажиллаж байна.

Судалгаанд хамрагдсан эмнэлгүүдийн дийлэнх нь шинэ болон дахин сэргэж байгаа халдварт өвчний дэгдэлтийн үед ажиллах шуурхай ажлын хэсгийг олон байгууллагуудын төлөөлөлтэйгээр байгуулсан нь сайшаалтай юм. Шуурхай ажлын хэсгүүдийн гуравны хоёр орчим хувь нь үйл ажиллагааны оператив төлөвлөгөө боловсруулсан боловч үйл ажиллагаанд зориулсан төсөв ерөнхийдөө хангалтгүй байна. Сүүлийн нэг жилийн хугацаанд шинэ болон дахин сэргэж байгаа халдварт өвчний талаар сургалтуудыг эмнэлгийн эмч, ажиллагсдын дунд 2-оос доошгүй удаа дотооддоо зохион байгуулсан дэмжүүштэй ажил болжээ.

Эмнэлгийн тусгаарлах өрөө, түүний нөхцөл байдал хангалтгүй байна.

Дийлэнх эмнэлгүүдэд гоц халдвараар өвдсөн өвчтөнг тусгаарлах өрөө гаргаж, бэлтгэсэн нь сайшаалтай боловч зарим газруудад өрөөний байрлал нь халдвар эсэргүүцэх дэглэм хангаж чадаагүй, мөн дийлэнх нь агааржуулалтын болон битүүмжлэлийн систем суурилуулаагүй байна. Харин олон улсын байгууллагаар санхүүжигдсэн өрөөнүүд нь стандартад нийцсэн, үлгэр болохуйц түвшинд тохиожсон байв. Эрүүл мэндийн байгууллага тэр дундаа сумын жижиг эмнэлгүүдэд ийм өрөө тусгайлан бэлтгэхэд санхүүгийн асуудал хамгийн хүнд байна. Даралтын аппарат, амбу, чагнуур, аюулгүй хайрцаг нь тусгаарлах өрөөний үндсэн багаж, хэрэгслүүд болж байна. Харин эмчилгээний зориулалттай өртөг өндөр багаж, хэрэгсэлтэй өрөө тун ховор байна. Тусгаарлах өрөөнд байх ёстой яаралтай тусламжийн эмийн төрөл, тоо хэмжээ ч цөөн байна.

Эмнэлгүүдэд багаж, хэрэгслийн бэлэн байдал, хүртээмж хангалтгүй байна.

Үйлчилгээний хамрах хүрээ, үйлчлүүлэгчийн тоо болон шувууны томуу дэгдэх эрсдэлтэй харьцуулахад эмнэлгүүдэд байгаа хамгаалах хувцас, хэрэгслийн хангамж, хүртээмж хэд дахин доогуур байна. Нэг удаагийн хувцас хэрэгслийн нийлүүлэлт бага, өртөг өндөр учраас эмнэлгүүд тэр бүр ашиглахгүй байна. Ариутгалын үйл ажиллагаанд ашиглах төхөөрөмж, бодисын хүрэлцээ, хангамж мөн л муу байна.

Эмнэлгүүдэд нарийн мэргэжлийн боловсон хүчний хангалт, нарийн оношлогоо, шинжилгээ хийх чадамж муу байгаа нь шувууны томуугийн сэжигтэй тохиолдол илэрсэн үед цаг хугацаа алдах, халдвар тархах эрсдэлийг нэмэгдүүлж байна.

Эрүүл мэндийн байгууллагууд тэр дундаа орон нутгийн эмнэлэгт их эмч, нарийн мэргэжлийн их эмчийн эрэлт хэрэгцээ өндөр байна. Цусны болон бактериологийн шинжилгээ хийх төхөөрөмж, мэргэжлийн боловсон хүчин орон нутагт байхгүй байна. Орон нутагт оношлогооны багаж, төхөөрөмж хангалтгүй байгаагаас бэлгийн замын халдварт хэдэн өвчнийг оношлож байгаа боловч агаар дуслын замаар халдварлах өвчний оношлогоог орон нутагт хийхгүй байгаа нь цаг хугацаа алдах, халдвар түгээх эрсдэлийг нэмэгдүүлж байна.

Дүгнэлт

Шийдвэр гаргагчдын хувьд:

Шувууны томууны цартахал, түүний бэлэн байдлын талаар шийдвэр гаргагчдын тал гаруй хувь нь бүрэн зөв мэдлэгтэй байгаа бөгөөд тэдгээрийн мэдлэгийн түвшин өмнөх судалгааны үр дүнтэй харьцуулахад эрс дээшилжээ. Үүнийг өмнөх судалгаанаас хойш шийдвэр гаргагчдад чиглэсэн үйл ажиллагааны томоохон үр дүн гэж дүгнэж болохоор байна. Гэвч засаг захиргааны нэгж

жижигрэх тусам шийдвэр гаргагчдын бодит мэдлэгийн түвшин доогуур байна.

Шувууны томуу, томуу өвчинтэй тэмцэх, сэргийлэх арга хэмжээний тухай гарсан тогтоол, шийдвэр, дүрэм журмын талаар шийдвэр гаргагчид мэдээлэл, мэдлэг сайтай байгаа бөгөөд шувууны томуу, томуу өвчинтэй тэмцэх эрх зүйн үндэс бүрдэж, засаг захиргааны нэгж, удирдлагууд өөрсдийн удирдамж, захирамж, ажлын төлөвлөгөө гарган хэрэгжүүлэх арга хэмжээ авдаг болох нь харагдаж байна. Гагцхүү хөрөнгө санхүүгийн асуудал ялангуяа, үг өвчнөөс урьдчилан сэргийлэх, цартахлын үеийн бэлэн байдлыг хангаж ажиллахад зориулагдсан тусгайлсан төсөв байхгүй байгаа явдал аливаа тогтоол, тушаал, шийдвэр, журмыг хэрэгжүүлэхэд учирч буй гол бэрхшээл болж байна.

Олон нийтийн хувьд:

Олон нийтийн судалгаанд хамрагдагсдын дийлэнх нь өмнөх судалгааны нэгэн адил шувууны томуу өвчний талаар сонссон, хүүхэд, насанд хүрэгчдээр ангилж үзвэл, хүүхдүүдийн шувууны томуугийн талаар сонссон гэсэн хувь насанд хүрэгчдийнхээс 12.3-15.2 пунктээр бага байгаа боловч өмнөх суурь судалгааны дүнгээс 1.0 пунктээр нэмэгдсэн бөгөөд 90 гаруй хувь нь шувууны томуугийн талаар телевизээс мэдээлэл сонссон ба мэдээлэл авдаг эх үүсвэрүүдийн дундаж тоо 2 байв.

Өмнөх суурь судалгааг бодвол судалгаанд хамрагдагчдын шувууны томуугийн халдвар дамжих замуудын талаарх ойлголтонд ерөнхийдөө нэлээд дэвшил гарсан гэж дүгнэж болно. Хэдий тийм боловч сурсан, мэдсэнээ амьдралд хэрэгжүүлэх, дадал хэвшил болгон амьдрах, урьдчилан сэргийлэх талаар дутагдалтай хэвээр байна.

Шувууны аж ахуй эрхлэгчдийн хувьд:

Шувууны аж ахуй эрхлэгчдийн шувууны томуугийн талаарх мэдлэгийн түвшинг

харьцангуй хангалттай гэж үнэлж болно. Ялангуяа шувууны томуугийн хүний өвчлөл болон шувууны өвчний илрэх шинж тэмдэг, шувууны томуугийн хүнд болон шувуунд халдварлах арга замын тухайд хангалттай зөв ойлголт, мэдлэгтэй байна. Хэвшсэн буруу дадал зуршил, зан үйл бараг байхгүй ч, хэнэггүй байдал, халдваргүйжилт, ариутгал, хорио цээрийн дэглэм сахих талаар хангалттай биш байна.

Шувууны аж ахуй эрхлэгчид өөрсдийгөө шувууны томуугийн хүний өвчлөлөөр өвчлөх, халдварлах эрсдэл өндөртэй гэж үзэж байна. Учир нь шувууны томуу өвчин нь халдварлагдсан эд юмс, тээврийн хэрэгсэл, амьтны тэжээл, шувууны тор, ажиллагсдын хувцас хунараар дамжин тархах магадлал маш өндөртэй байдаг. Мөн шувууны аж ахуйд ажиллагсдын хувьд зориулалтын хамгаалалтын хувцас хэрэгсэл хангалтгүй, томуунаас урьдчилан сэргийлэх мэдлэгийн түвшин бага, тэдний дунд шувууны томуугийн тухай мэдээ мэдээлэл түгээх, сургалт, сурталчилгаа явуулах ажил хангалттай байж чадахгүй байна.

Эмнэлгийн удирдах болон нийгмийн эрүүл мэндийн ажилтнууд, их эмч, бага эмч, сувилалч нарын хувьд:

Нийт судалгаанд хамрагдагчдын 44 хувь нь шинэ болон дахин сэргэж буй халдварын талаар Засгийн газар, ЭМЯ, бусад байгууллагаас гарсан тогтоол, тушаал, зааврыг мэдэхгүй байна.

Шувууны болон хүний томууны талаарх мэдлэг сумын төв/хөдөөд Улаанбаатар, аймгийн төвтэй харьцуулахад бараг ялгаагүй байгаа хэдий ч мэдээлэл авах, сургалтанд хамрагдах, хүний нөөц, техник хэрэгслээр хангагдах боломж бага байна.

Эмнэлгийн бэлэн байдлын хувьд:

Судалгаанд хамрагдсан эмнэлгүүдийн дийлэнх нь шинэ болон дахин сэргэж байгаа халдварт өвчний дэгдэлтийн

үед ажиллах шуурхай ажлын хэсгийг олон байгууллагуудын төлөөлөлтэйгээр байгуулсан нь сайшаалтай юм. Шуурхай ажлын хэсгүүдийн гуравны хоёр орчим хувь нь үйл ажиллагааны оператив төлөвлөгөө боловсруулсан боловч үйл ажиллагаанд зориулсан төсөв ерөнхийдөө хангалтгүй байна. Дийлэнх эмнэлгүүдэд гоц халдвараар өвдсөн өвчтөнг тусгаарлах өрөө гаргаж, бэлтгэсэн нь сайшаалтай боловч зарим газруудад өрөөний байрлал нь халдвар эсэргүүцэх дэглэм хангаж чадаагүй, мөн дийлэнх нь агааржуулалтын болон битүүмжлэлийн систем суурилуулаагүй байна. Түүнчлэн үйлчилгээний хамрах хүрээ, үйлчлүүлэгчийн тоо болон шувууны томуу дэгдэх эрсдэлтэй харьцуулахад эмнэлгүүдэд байгаа хамгаалах хувцас, хэрэгслийн хангамж, хүртээмж, ариутгалын бодисын хүрэлцээ, хангамж доогуур байна.

Бодлого, үйл ажиллагааны зөвлөмж

Судалгааны үр дүн дүгнэлт дээр тулгуурлан олон нийт, эмч, эмнэлгийн ажилтан, шувууны аж ахуй эрхлэгч, шийдвэр гаргагчдын томуугийн цартахлын бэлэн байдлын талаарх мэдлэг, хандлага, дадал, үүрэг оролцоо, хариуцлагыг нэмэгдүүлэхийн тулд дараах арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэхийг санал болгож байна. Үүнд:

А.Мэдээлэл, сургалт, сурталчилгааны хүртээмж, чанарыг дээшлүүлэх

- Нүүдлийн шувуудын тандалтын судалгааг хийх, эрсдэл өндөр бүлгийн айл өрх, хүн ам, ялангуяа хүүхэд, аж ахуйн нэгжийн бүртгэлийг шинэчилж, мэдээллийн санг бүрдүүлж, судалгааны болон үйл ажиллагааны тайланг бүх шатанд ил тод мэдээлэх, сонор сэрэмжийг нэмэгдүүлэх;
- Шувууны томуу, томуугийн цартахлын талаар зорилтот бүлгүүдийн хэрэгцээ, шаардлага, онцлогийг тусгасан сургалтын хөтөлбөр боловсруулж,

бүх шатны шийдвэр гаргагчид, бэлэн байдлыг хангаж ажиллах алба, ажлын хэсгийн гишүүд, төрийн болон төрийн бус байгууллагын ажилтнууд, ард иргэд, ялангуяа шувууны аж ахуй эрхлэгчдэд тусгайлсан хөтөлбөрийн дагуу зохион байгуулж, мэдлэгийн түвшинг дээшлүүлэх шаардлагатай байна. Үүний тулд юуны өмнө мэргэшсэн сургагч бэлтгэх, сургалтын материаллаг баазыг цогц байдлаар бүрдүүлж, хүртээмжийг нэмэгдүүлэхэд анхаарах;

Иргэд, олон нийт, иргэний нийгэм, олон нийтийн мэдээллийн хэрэгсэл болон бизнесийн байгууллагуудын оролцоо, хамтын ажиллагааг дэмжих замаар мэдээлэл, сургалт, сурталчилгааг өргөжүүлэх, чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх. Ялангуяа, ард иргэдэд хандсан үйл ажиллагааг эрчимжүүлэх;

Б. Хяналт, хариуцлагын тогтолцоог сайжруулах

- Шувууны томуу, томуугийн цартахлын үеийн бэлэн байдлыг хангаж ажиллах төлөвлөгөө, түүний хэрэгжилтийг сайжруулахын тулд холбогдох албан тушаалтнуудын ажил үүрэг, хариуцлага, хамтын хариуцлагын тогтолцоо, үйл ажиллагааны чиглэлийг нарийн тодорхойлж өгөх, үр дүнгийн шалгуур үзүүлэлтүүд боловсруулж, үйл ажиллагааг үнэлдэг болох. Түүнчлэн шувууны томуутай тэмцэх, урьдчилан сэргийлэх, цартахлын бэлэн байдлыг хангах талаар гарсан тушаал, шийдвэрийн хэрэгжилтийг бүс нутаг, аймгаар зэрэгцүүлэн үнэлж, хянах;

В. Эмнэлгийн бэлэн байдлыг хангах

- Эмнэлгүүдэд, ялангуяа эрсдэл өндөр нутаг дэвсгэрийн эмнэлгүүдэд тусгаарлах өрөөг стандартын дагуу байгуулах, зайлшгүй бэлэн байх ёстой эм, хэрэгсэл, тоног төхөөрөмжөөр онцгойлон хангах ба гоц халдварын үеийн хамгаалах хувцас, хэрэгслийн хүртээмж, чанарыг нэмэгдүүлэх;

Г. Хөрөнгө, санхүүгийн эх үүсвэрийг бүрдүүлэх, нэмэгдүүлэх

- Шувууны томуугийн эрсдлээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд аймаг, сум, дүүргийн хэмжээнд тусгайлан хөрөнгө төсөвлөх талаар зохих түвшинд шийдвэрлүүлэх.